



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 527

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 153,869,664.54 (нэг зуун тавин гурван сая найман зуун жаран есөн мянга зургаан зуун жаран дөрвөн төгрөг тавин дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 131,399,561.04 (нэг зуун гучин нэгэн сая гурван зуун ерэн есөн мянга таван зуун жаран нэгэн төгрөг дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Цагдаагийн ерөнхий газрын харьяа Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанд балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Мэргэн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржав болон тогтоолд заасан байгууллагын дарга дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН

ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002521

D:\Huraldaanii material\2018 on\2018.11.20\Togtool.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 11 дугаар сарын 27-ны өдрийн  
дугаар толболын хавсралт

"АВТОТЭЭВРИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД" ҮЙЛДЛЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ШУУРХАЙ  
УДИРДЛАГЫН АЛБАНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуимтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Сервер (Dell R820 intel хөөн E5-4650 /3ЦГ)	2015.12.31	ш	1	55,498,181.82	55,498,181.82	50,873,333.28	4,624,848.54
2	Хадгалах төхөөрөмж (Dell PS4210XV /3ЦГ)	2015.12.31	ш	1	56,272,727.27	56,272,727.27	51,583,333.23	4,689,394.04
3	Жолоочийн зөрчлийн оноо тооцох програм (epoint 3ЦГ)	2015.12.31	ш	1	42,098,755.45	42,098,755.45	28,942,894.53	13,155,860.92
	Нийт дүн					153,869,664.54	131,399,561.04	22,470,103.50